

## ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2007 ОНЫ 5 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

### Санхүү, эдийн засгийн чиглэлээр:

2007 оны эхний улиралд төсвийн нийт орлого 342.2 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 1.5 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 127.8 тэрбум төгрөгөөр буюу 59.7 хувиар өссөн байна. Аж ахуйн нэгж байгууллагын албан татвар 11.8 тэрбум, дотоодын бараа үйлчилгээний албан татварын орлого 7.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь татварын хуулийн шинэчлэл үр дүнгээ өгч байгаагийн илэрхийлэл боллоо. Улсын нэгдсэн төсвийн зарлага 269.5 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн нийт зарлагын 74.4 хувийг санхүүжүүлээд байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 92.8 тэрбум, нийт тэнцэл 72.7 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ. Монгол Улсыг хөгжүүлэх санд 186.2 тэрбум төгрөг төвлөрч, 28.5 тэрбум төгрөгийн зарлага гарснаар 157.7 тэрбумын үлдэгдэлтэй байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага 2007 оны эхний улиралд **386,7** тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зарлагын 79,3 хувийг санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс зарлага санхүүжилт 133,6 тэрбум төгрөгөөр буюу 52,7 хувиар илүү байна. Засгийн газар цалинг 2007 оны нэгдүгээр сарын 1-нээс төрийн албан хаагчдын цалинг 20 хувиар, өндөр насны тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэх, улмаар нийгмийн халамж, үйлчилгээний нөхөн олговрын хэмжээг тэлэх дэс дараатай арга хэмжээ авсан нь төсвийн зарлага нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсөвт **2007 оны эхний 4 сарын байдлаар** нийт орлого **452.2** тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөөг 13,4 тэрбум төгрөгөөр буюу 3.1 хувиар давуулан биелүүлж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 159.3 тэрбум төгрөгөөр буюу 54.4 хувиар илүү байна. Зарим барааны үнийн өсөлтийн албан татвараас өнөөдрийн байдлаар **45,2** тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлсний 98.9 хувийг буюу 44,7 тэрбум төгрөгийг Эрдэнэт улсын үйлдвэрийн газраас оруулсан байна. Алт, зэсийн үнэ дэлхийн зах зээл дээр 2007 оны эхний улиралд зохих хувиар унасны улмаас зарим барааны үнийн өсөлтийн албан татварын орлого 30,9 тэрбум төгрөгөөр тасарсан явдал төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтэд нөлөөлсөн байна.

Хөрөнгө оруулалтын санхүүжилт гүйцэтгэлээр (*өссөн дүнгээр*) 27.8 тэрбум төгрөгт хүрч, 51.2 хувийн, түүнчлэн дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт 23.5 тэрбум төгрөгт хүрч, 47.0 хувийн тус тус гүйцэтгэлтэй гарсан байна. Хөрөнгө оруулалтын зарим ажлын тендер шалгаруулалт бэлэн болоогүйгээс хөрөнгийн зардлын санхүүжилт нэлээд бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 5,6 тэрбум төгрөгөөр давж, зарлага 8,0 тэрбум төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна. Орлогын төлөвлөгөөг Говь-Алтай, Завхан, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл аймаг тасалсан бөгөөд бусад аймаг орлогын төлөвлөгөөг 0,6-47,8 хувиар давуулан биелүүлсэн байна. Улсын төсөвт орон нутгаас нийтдээ 6,9 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 5,2 тэрбум төгрөг төвлөрсөн бөгөөд Сэлэнгэ аймаг оны эхнээс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 600,0 сая төгрөгөөр тасалсан явдал түүнд шууд нөлөөлсөн байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн (*өссөн дүнгээр*) 2007 оны эхний дөрвөн сарын урсгал тэнцэл **113,3** тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл **65,5** тэрбум төгрөгийн ашигтай (*үүнээс*: улсын төсвийн урсгал тэнцэл 114,1 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 79,2 тэрбум төгрөгийн ашигтай) гарсан байна.

Улсын төсөвт байгууллагын 2007 оны дөрөвдүгээр сарын төсвийн зарлагын гүйцэтгэлийн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч нараар нэгтгэн гаргаж мэдээлэв. Улс, орон нутгийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын 2007 оны **дөрөвдүгээр сарын**

өглөг, авлагын мэдээг батлагдсан маягтын дагуу нэгтгэн гаргаж, ОУВС-д хүргүүлсэн байна. Улсын хэмжээнд 2007 оны тавдугаар сарын 1-ний байдлаар нийт авлага 5.74 тэрбум, нийт өглөг 6.37 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан дүн мэдээтэй байна.

Батлагдсан төсвийн хуваарийн дагуу 2007 оны хоёрдугаар улиралд улс, орон нутгийн төсөвт байгууллагын төсвийн урсгал зардлын эрхийг хянаж, нийтдээ тавдугаар сард 117.6 төгрөгийн урсгал санхүүжилтийг хугацаанд нь олгосон байна. Тухайлбал, халамжийн тэтгэвэрт 3109.8 сая төгрөг, тэтгэврийн даатгалын санд 8534.0 сая төгрөг, тэтгэврийн нөхөн олговорт 29.9 сая төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжид 2760.9 сая төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох тэтгэмжид 29.3 сая төгрөг, шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламжид 390.1 сая төгрөг, шинээр гэрлэгчдийн мөнгөн тусламжид 2500.0 сая төгрөг, эрчим хүчний алдагдлын зөрүүг нөхөхөд 125.0 сая төгрөг, улс, орон нутгийн төсөвт байгууллагын урсгал зардалд 126,3 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлсэн байна.

Аймаг, нийслэлийн Засаг дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нартай байгуулсан гэрээний санхүүжилтийн эрхийн тооцоог хийж, түүнийг цахим сүлжээгээр дамжуулсан байна. Мөн 2007 оны эхний таван сард орон нутагт олгох НӨАТ-ын шилжүүлгээр 15.1 тэрбум төгрөг (тухайн сард 1071.6 сая төгрөг), санхүүгийн дэмжлэгээр 24.1 тэрбум төгрөг (тухайн сард 2686.6 сая төгрөг)-ийг хуваарилан олгов.

Засгийн газрын нөөц сан, Монгол Улсыг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын төсөв, түүний гүйцэтгэлийг хянаж, тайланг нэгтгэн гаргаж ажиллав. Засгийн газрын шийдвэрийн дагуу 2007 оны эхний таван сарын гүйцэтгэлээр Засгийн газрын нөөц сангаас 1148.0 сая төгрөг (тухайн сард 452.6 сая төгрөг)-ийг зарцуулжээ. Монгол Улсыг хөгжүүлэх сангаас 2007 оны эхний таван сард хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 27.9 тэрбум төгрөг (тухайн сард 25301.4 сая төгрөг), “Үдийн цай” хөтөлбөрийн зардалд 5.5 тэрбум төгрөг (тухайн сард 1104.3 сая төгрөг), хүүхдийг дэмжих мөнгөнд 49.2 тэрбум төгрөг (тухайн сард 49.4 тэрбум төгрөг), нийтдээ 82.6 тэрбум төгрөгийн санхүүжилт гарсан байна. Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангаас 2007 оны 4 дүгээр сард дамжуулан зээлдүүлэх зээлийн эх үүсвэрт 4,0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2007 оны төлөвлөгөөний дагуу яамдаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын 249 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хүсэлтийг хянаж, 2007 оны 5 дугаар сард бүх эх үүсвэрээр 33.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эрхийг нээсэн байна. Улсын хөрөнгө оруулалтаар 2007 оны эхний таван сарын байдлаар нийтдээ (өссөн дүнгээр) хөрөнгө оруулалтын 16.48 тэрбум төгрөг (улсын төсвийн хөрөнгө оруулалтад 3879.0 сая төгрөг, их засварт 653.6 сая төгрөг, тоног төхөөрөмжид 623.8 сая төгрөг, авто замын хөрөнгөөр 216.7 сая төгрөг)-ийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Өрийн удирдлагын DMFAS-ийн мэдээллийн баазад 2007 оны эхний таван сарын байдлаар хэрэгжүүлж буй төслийн тоо мэдээллийг оруулж, дүн мэдээг бүрэн тусгаж ажилласан байна. Засгийн газар 2007 оны эхний таван сард (өссөн дүнгээр) гадаад зээлийн үндсэн төлбөрт 15.3 тэрбум төгрөг (тухайн сард 2.6 тэрбум төгрөг), хүүгийн төлбөрт 6.5 тэрбум төгрөг (тухайн сард 1.1 тэрбум төгрөг), нийт 21.8 тэрбум төгрөг төлсөн байна. Арилжааны банкуудаас дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу 2007 оны эхний таван сард (өссөн дүнгээр) зээлийн үндсэн төлбөрт 3589.7 (тухайн сард 254.9 сая төгрөг), хүүгийн төлбөрт 4174.9 (тухайн сард 877.3 төгрөг), нийт 7.76 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын өрийн бичиг, үнэт цаасны дэлгэрэнгүй тайланг 2007 оны эхний таван сарын байдлаар гаргаж, удирдлагад танилцуулсны хамт 2007 оны эхний таван сард Засгийн газрын бондын үндсэн төлбөрт 4505.2 сая төгрөг, хүүгийн төлбөрт 310.7 сая төгрөг, бүгд 4.81 тэрбум төгрөг төлсөн байна. Засгийн газрын үнэт

цаасны 2007 оны арилжааны хуваарийн дагуу Засгийн газрын үнэт цаасны 128 дугаар арилжааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан (2007 оны 5 дугаар сарын 24-ний өдөр) зохион байгуулж арилжаагаар 4.8 тэрбум төгрөгийн орлогыг төрийн санд төвлөрүүлсэн байна. Түүнчлэн Засгийн газрын үнэт цаасны 126 дугаар арилжааны 28 хоногтой үнэт цаасны 1.0 тэрбум төгрөгийн буцаан төлбөрийг гүйцэтгэсэн байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдэл 2007 оны эхнээс 72.3 тэрбумаар нэмэгдэж 2007 оны 6 дугаар сарын нэгний байдлаар 534.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэхүү төрийн сангийн мөнгөн хөрөнгийн сул чөлөөтэй эх үүсвэрээс Монголбанк, арилжааны банкуудад төгрөгийн ба валютын богино хугацаат хадгаламж байршуулж, 2007 оны эхний таван сарын байдлаар 4.6 тэрбум төгрөг (тухайн сард 462.4 сая төгрөг)-ийн хүүгийн орлого олсон дүнтэй гарч байна.

Төсөвт байгууллагын батлагдсан төсвийн хүрээнд байгуулсан худалдан авалтын гэрээ, захиалгын хуудсыг үндэслэн 2007 оны эхний таван сард (*өссөн дүнгээр*) нийт 1591 (тухайн сард 436) тооны амлалтыг бүртгэж, 4781.0 сая төгрөг (тухайн сард 723.5 сая төгрөг)-ийг нөөцөлж, тухайн төсөвт байгууллагын батлагдсан төсвөөс нөөц үүсгэсэн амлалтаас 4239.9 сая (тухайн сард 527.5 сая төгрөг) төгрөгийн гүйлгээг бэлтгэн нийлүүлэгч байгууллагад шилжүүлэн санхүүжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Дэлхийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй нийт 11 төслийн төлбөр гүйцэтгэх хүсэлтийг холбогдох журмын дагуу хянан үзэж, зохих санхүүжилтийг шийдвэрлэж олгосон байна. Төслийн бус буцалтгүй тусламжийн сангийн бүрдүүлэлт, холбогдох байгууллагын гэрээний биелэлтэд хяналт тавьж, улмаар тусламжийн барааны орлого төвлөрүүлэлтийн сарын мэдээг нэгтгэн гаргасан байна. Түүнчлэн Засгийн газрын шугамаар буцалтгүй тусламжийн хэлбэрээр импортоор нийлүүлэгдэж буй бараа, материал, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлүүлэх тухай ирүүлсэн хүсэлтийг хянан үзэж, 2007 оны 5 дугаар сарын 31-ний байдлаар **3,362,558.6** мянган төгрөгийн үнэ бүхий бараанд **51** удаагийн зөвшөөрлийг олгосон байна.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Санхүүгийн зохицуулалт ба засаглалын хөтөлбөр”-ийн ажлын хэсгийн хуралдааны санал, дүгнэлтийг үндэслэн Сангийн яам, Азийн хөгжлийн банкны хооронд Харилцан ойлголцлын санамж бичигт хоёр тал гарын үсэг зурсан байна.

“Хот суурин газрын ядуу иргэдийн оролцоотойгоор гэр хорооллыг хөгжүүлэх” буцалтгүй тусламжийн гэрээнд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Азийн хөгжлийн банкыг төлөөлж Монгол Улсад суугаа Суурин төлөөлөгч нар гарын үсэг зурсан байна.

Азийн хөгжлийн банкны Ядуурлыг бууруулах Японы сан (ЯБЯС)-аас Монгол Улсын хот суурин газрын хөгжилд орлого багатай иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 1.5 сая ам.долларын буцалтгүй тусламжийг олгохоор боллоо.

Монгол Улсын Сангийн яам, Дэлхийн зөн Олон улсын байгууллагын хооронд Түншлэлийн гэрээг байгуулж, түүнд хоёр тал гарын үсэг зурсан байна. Энэхүү Түншлэлийн гэрээг байгуулснаар ирэх 10-15 жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан нийтдээ 150-200 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх боломж бүрдэх бөгөөд түүний үр шимийг 600-900 мянган хүүхэд, ард иргэд хүртэх юм.

Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Дэлхийн зөн Олон улсын байгууллага хамтран Боловсролын салбарт 2007-2008 онуудад хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулж, гарын үсэг зурсан байна.

Зүрх судасны өвчний оношлогоо, эмчилгээ, хяналтын чанарыг дээшлүүлэх зорилго бүхий төслийн нэг сая еврогийн өртөгтэй эхний үе шат амжилттай хэрэгжиж дууссан бөгөөд хоёр дахь үе шатны төслийн Харилцан ойлголцлын санамж бичигт Сангийн сайд, Люксембургын Вант Улсын Хятад дахь Элчин сайд нар гарын үсэг зурсан байна. Зүрх

судасны төвийн хоёр дахь үе шатны төсөлд Люксембургийн Вант Улсын Засгийн газар 3 жилийн хугацаанд нийт 2,4 сая еврог зарцуулна.

### Хууль зүйн салбарт:

Улсын Их Хурлын гишүүдээс санаачлан боловсруулсан Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай, Статистикийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, “МОНЦАМЭ” агентлагийн тухай, Хүн ам, орон сууцны тооллогын тухай хуулийн төсөл, “Агаарын бохирдлыг бууруулах талаар яаралтай хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд өгөх Засгийн газрын санал дүгнэлтийн төслийг тус тус боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан “Гаалийн шинэчлэл, модернизаци төслийн зээл”-ийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай, Монгол Улсын Засгийн газар, Бельгийн Вант Улсын хооронд байгуулсан “Зүүн бүсийн оношлогоо, эмчилгээний төвийг бэхжүүлэх төсөл”-ийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай, Онцгой албан татварын тухай болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, “Монгол Улсын 2006 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг батлах тухай”, “Хүн амыг орон сууцаар хангах, барилгын салбарт ажлын байр нэмэгдүүлэх хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгов.

Орон сууцны тухай, Технологи дамжуулах тухай, Үндэсний их баяр наадмын тухай, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай, Зээлийн хоршооны үйл ажиллагааны журмын тухай, Импортоор нийлүүлэх хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэх тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар ноогдуулахгүй байх тухай, “Чойр” эдийн засгийн чөлөөт бүсийн тухай, Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай, Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн протоколд оруулсан Бээжингийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай, Парламентын ордон барих төслийн буцалтгүй тусламжийн харилцан ойлголцлын санамж бичгийг соёрхон батлах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Жагсаалт батлах тухай”, “Төсвийн хүрээний мэдэгдлийг зөвшөөрөх тухай”, “Монгол Улсын 2006 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг тус тус хянаж, зохих арга хэмжээг авав.

Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Гаалийн тухай, Гаалийн тарифын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын протоколд оруулсан Бээжингийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл, “Шинээр гэр бүл болсон иргэдийн тэтгэмжийн хөрөнгийг шийдвэрлэх тухай”, “Орон нутгийн өмчийн зарим эд хөрөнгийг төрийн өмчид хүлээн авах тухай” Улсын Их Хурлын 2 тогтоолын төсөл, “Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулж байх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн төсөл, “Улсын нөөцөөс улаан буудайн үр гаргаж нөхөн бүрдүүлэх тухай”, “Найдваргүй болсон төлбөрөөс чөлөөлүүлэх тухай”, “Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ажилчдын орон сууцны тухай”, “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай”, “Сумдын төвийн цахилгаан хангамжийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тухай”, “Сум, суурин газрын дулаан хангамжийн хэрэгжилтийн тухай”, “Монгол Улсын хөгжүүлэх сангийн ажлын алба байгуулах тухай”, “Үндэсний спортыг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай”, “Мянган малчны чуулганыг зохион байгуулах тухай”, “Өвсний үнэ чөлөөлүүлэх

тухай”, “Орон нутгийн нисэх буудлуудыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” зэрэг Засгийн газрын 33 шийдвэрийн төсөлд тус тус санал бэлтгэж хүргүүлээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр Монгол Улсын Ерөнхийлөгчийн БНСУ-д хийх төрийн айлчлалын бүрэлдэхүүнд ажиллаж уг айлчлалын үеэр “Монгол Улс, БНСУ-ын хооронд ялтан шилжүүлэх тухай гэрээ”-нд гарын үсэг зурлаа.

“Иргэний бүртгэл, паспорт-хяналтын нэгдсэн сүлжээг ашиглахад дагаж мөрдөх журам”, “Хууль, хууль тогтоомжийн эмхтгэл /Төрийн мэдээллээс бусад/ хэвлэх үйл ажиллагаа эрхлэх этгээдийг сонгон шалгаруулах журам”, “Мэдээллийн нэгдсэн сүлжээ болон компьютерийг ашиглах, түүний нууцыг хадгалах, хамгаалах журам”-уудыг Хууль зүй, дотоод хэргийн сайд батлав.

Мөн “Хууль зүй, дотоод хэргийн яаманд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ыг Төрийн нарийн бичгийн дарга шинэчлэн баталж мөрдүүлж байна. Уг журмаар иргэдээс цахим хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, санал хүсэлтийг хэрхэн хариу өгч, шийдвэрлэх асуудлыг нэмж зохицуулсан болно.

Тайлангийн хугацаанд холбогдох төрийн захиргааны байгууллагуудын зөвшөөрлийг үндэслэн Монгол Улсад албан хэргээр удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл гадаадын иргэн 4747 хүнд олгож, 1095 хүний оршин суух зөвшөөрлийг сунгаж, нутаг буцсан 988 хүнийг бүртгэлээс хассан байна.

Монгол Улсад түр хугацаагаар ирсэн гадаадын иргэн 4039 хүнийг бүртгэж, нутаг буцсан 3782 хүнийг бүртгэлээс хассан болно.

Дээрхи хугацаанд албан болон хувийн хэргээр түр буюу удаан хугацаагаар ирэх гадаадын иргэдэд холбогдох төрийн захиргааны байгууллага, иргэдийн хүсэлтийг үндэслэн “орох” 3507, “орох-гарах” 368, “олон удаагийн” 176, нийт гадаадын 4051 иргэнд визийн зөвшөөрөл өгсөн байна. Мөн “гарах-орох” 430, “гарах” 552, олон удаагийн 552, нийт 1534 виз олгож, 649 визийн ангилал солин, 698 визийг сунгажээ.

### **Гадаад хэргийн чиглэлээр:**

ОХУ-ын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн дарга С.Миронов 2007 оны 5 дугаар сарын 14-17-нд Монгол Улсад айлчлав. Түүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нар хүлээн авч уулзав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын БНСУ-д хийх айлчлалын үеэр байгуулахаар төлөвлөсөн хэлэлцээрүүдийн төслийг солонгосын талтай тохиролцож гарын үсэг зурахад бэлэн болгов.

ЛБНАфгУ-аас МУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эклил Ахмад Хакими 5 дугаар сарын 14-ний өдөр Ерөнхийлөгч Н.Энхбаярт ИЖБ-ээ барив. Элчин сайдыг ГХ-ийн сайд Н.Энхболд, ҮХ-ны сайд Ц.Даваадорж нар хүлээн авч уулзав.

Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Нургалиев Гадаад хэргийн сайд Н.Энхболдын урилгаар 2007 оны 4 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгын дагуу БНАЛАУ-ын Ерөнхийлөгч Чумали Саяасон энэ оны 7 дугаар сарын 3-6 нд Монгол Улсад айлчлахыг Лаосын тал албан ёсоор мэдэгдэв.

“Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Финланд Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурах бэлтгэл ажлыг хангаж 5 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурав.

Монгол Улсыг АПЕК-т элсэхэд дэмжлэг хүссэн захидлыг Гадаад хэргийн сайд Н.Энхболдоос Мексик, Чили, Сингапурын Гадаад хэргийн сайд нар, АПЕК-ийн гүйцэтгэх нарийн бичгийн даргад илгээв.

Гадаад хэргийн сайдын Скандинавын орнуудад хийх айлчлалын бэлтгэлийг ханган ажиллав. ГХЯ-ны 2007 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Гадаад хэргийн сайд Н.Энхболд 2007 оны 5 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд Шведийн Вант Улсад, 5 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд Данийн Вант Улсад, 6 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд Норвегийн Вант Улсад тус тус айлчлал хийж, 5 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд Германы Хамбург хотноо болох АСЕМ-ын гишүүн орнуудын Гадаад хэргийн сайд нарын уулзалтад оролцохоор төлөвлөж, холбогдох талуудтай тохиров.

Люксембургийн Элчин сайд Марк Унгохоер бүрмөсөн буцаж байгаатай холбогдуулан Монгол Улсад 5 дугаар сарын 14-16-нд ажлын айлчлал хийв. Элчин сайд М.Унгохоер Сангийн сайд Н.Баяртсайхан нар Люксембургийн талаас Монгол Улсад Зүрх судасны эмчилгээ, оношлогооны төв байгуулах төслийн 2 дугаар үе шатыг санхүүжүүлэхэд зориулан 2.4 сая еврогийн буцалтгүй тусламж олгох тухай Санамж бичигт гарын үсэг зурав.

УИХ-ын даргыг 9 дүгээр сарын 10-12-нд Унгарт, 13-16-нд Чехэд, 17-20-нд ХБНГУ-д тус тус айлчлуулахаар холбогдох ЭСЯ-нд үүрэг өгөв.

Италийн Элчин сайд Рикардо Сесса Монгол Улсын Ерөнхийлөгчид 5 дугаар сарын 14-ний өдөр итгэмжлэх жуух бичгээ барив.

Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Бэхбат тэргүүтэй төлөөлөгчид 5 дугаар сарын 2 – 16 –ны өдрүүдэд Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс, Бүгд найрамдах Аргентин Улс, Бүгд Найрамдах Чили Улс, Мексикийн Нэгдсэн Улсад тус тус ажлын айлчлал хийв.

Кувейтын Эмирийн айлчлалтай холбогдуулан Элчин сайд нь 5 дугаар сарын 16–17-нд ирж ажиллав. Элчин сайд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Гадаад хэргийн сайд нартай тус тус уулзав.

Кувейтын сангийн дэд захирал тэргүүтэй төлөөлөгчид 4 дүгээр сарын 23 – 26 –нд ажлын айлчлал хийж, Парламентын ордон барих тухай санамж бичигт гарын үсэг зурав.

Кот Дивуар Улсын элчин сайд 4 дүгээр сарын 26-нд ИЖБ-ээ барив. ИЖБ барихтай нь холбогдуулан Гадаад хэргийн сайд хүлээн авч уулзав.

Алматы хотноо болж буй АНДЭЗНК-ын 63 дугаар чуулганд оролцох бэлтгэл ажлыг хангаж ажиллав. Чуулганд Шадар сайд тэргүүтэй төлөөлөгчдийг оролцуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлсэн.

Сөүл хотноо 2007 оны 6 дугаар сарын 4-6-д болох АСД-ийн сайд нарын уулзалтын бэлтгэл ажлыг хангаж байна. Уулзалтад Гадаад хэргийн сайд тэргүүтэй төлөөлөгчдийн оролцуулах асуудлыг Засгийн газрын 2007.05.16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

Японы Гадаад хэргийн дэд сайд К.Асано 4 дүгээр сарын 28-наас 5 дугаар сарын 2-ны өдрүүдэд ажлын айлчлал хийсэн ба Гадаад хэргийн сайд Н.Энхболдын хамт Хүний нөөцийн тэтгэлэгт хөтөлбөрийн 310 сая иений ноот бичигт гарын үсэг зурав.

Иргэд гадаадад зорчих нөхцлийг хөнгөвчлөх үүднээс Бразилтай дипломат, албан паспорт эзэмшигчдийг визнээс чөлөөлөх хэлэлцээр байгуулж, Солонгостой иргэд 90 хүртэлх хоногоор харилцан зорчих, Казахстанд зорчих монгол иргэдийг ОХУ-ын нутгаар визгүй дамжин өнгөрүүлэх санал тавьж ноот өгөв.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын ЗГХК-ын XIII хуралдааны бэлтгэл ажил хийгдэж байна.

Хилийн чанадад Монголын харъяатаас гарсан, нас барсан, сураггүй алга болсон, бусдад дээрэмдүүлсэн, хорих ял эдэлж байгаа болон саатуулагдсан, гэмт хэрэг үйлдсэн, эмчлүүлэхийг хүссэн, үйлдвэрлэлийн осолд орсон, бусдад зодуулсан, хууль бусаар

зорчсон, гадаадын орноос албадан буцаагдсан, бусад орны виз хүссэн зэрэг 49 иргэний асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллав.

Засгийн газрын хуралдаанаас шийдвэрлэсний дагуу НҮБ-ын албан хаагчдыг визээс чөлөөлөх санал тавьж НҮБ-ын НБДНГ-т ноот илгээв. Гадаад иргэдийн паспортыг хураахгүй байх талаар ХЗДХЯ-нд тоот илгээж, 90 гаруй вьетнам иргэдийн паспортыг шалгаж зөрчлийн улмаас хураасан тайлбарыг ноотоор ЭСЯ-нд нь хариу мэдэгдэв.

Бүтээгдэхүүний загварын олон улсын бүртгэлийн Гаагийн хэлэлцээрийн 1999 оны Женевийн актад нэгдэн орох тухай хуулийн төсөл, үзэл баримтлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газарт хүргүүлэв.

Хил дамнасан тамхины наймаатай тэмцэх ажлын хүрээнд 2006 оны 1 дүгээр сард гарсан ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 14 дүгээр тушаалын дагуу ДТГ-уудын ажилтнууд хувийн хэрэгцээндээ том оврын автомашинтай байхыг хориглосон тул энэ тушаалын хэрэгжилтийн байдлыг шалгаж илэрсэн зөрчлүүдийг арилгуулах талаар арга хэмжээ авч байна.

Цөмийн, цацраг идэвхт бусад материалыг хууль бусаар наймаалахаас урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах талаар АНУ-ын Эрчим хүчний департаменттай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хийв.

### **Байгаль орчны салбарт:**

Ойн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн 2007 оны 5 дугаар сарын 17-ны өдөр батлуулж, “Биоаюулгүй байдлын тухай хууль”-ийн төслийг УИХ-ын нэгдсэн хуралдаанд анхны хэлэлцүүлгээр оруулав.

Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн, үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд, “Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг Засгийн газарт хэлэлцүүлэхээр хүргүүлж, “Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын их хуралд өргөн мэдүүлэхээр зөвшөөрүүлэв.

Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээ (УЦУОХШ)-ний салбарыг 2015 он хүртэлх хугацаанд хөгжүүлэх хөтөлбөрийн дунд шатны /2007-2010/ зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлав.

Эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнгээс үзэхэд байгаль орчны бодлогын чиглэлээр 9 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс эхний 5 сарын байдлаар хэрэгжилтийн дундаж 53.0%-тай байна. Одоогоор Байгаль орчны сайдын удирдан хэрэгжүүлэх арга хэмжээний заалтуудаас хугацаандаа хэрэгжих боломжгүй заалт байхгүй байна.

Дэлхийн байгаль хамгаалах өдрийг угтан “Аврал эрсэн байгалиа хамгаалцгаая” аяныг 5 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 5-ны хооронд зохион байгуулав.

Говийн Бага Дархан цаазат газрын “Б” хэсгийн Модон шанд орчимд хууль бусаар алт олборлож байсан үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор ЦЕГ, УМХГ-тай хамтран хяналт шалгалтын баг томилж ажиллуулав.

Хангай, Төв, Баруун, Зүүн бүс тус бүрээс нэг гол, нэг нуурыг хамгаалалтанд авах төрийн тахилгат нутгаар баталгаажуулах гэж буйтай холбогдуулан танилцуулга, гидрогеологийн өгөгдлийг боловсруулж хүргүүлэв.

Усны нөөц ашиглуулах тухай мэргэжлийн дүгнэлтийг алтны шороон орд олборлож байгаа 7 аж ахуйн нэгжид гаргаж, 2007 онд шинээр барих ба сэргээн засварлах услалтын системүүдийн зураг төсөлд мэргэжлийн дүгнэлт өгөв.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт үүссэн усны эх үүсвэрийн химийн хорт бодисын бохирдлыг тогтоох, саармагжуулах арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулав.

4-р сарын турш хийгдсэн цаг агаарын мэдээний таарцыг дүгнэхэд 73.2 хувь болж төлөвлөгөөт даалгавраас 11.2 хувь, өнгөрсөн оны мөн үеийнхээс 11.6 хувиар ахисан байна. Дулааны улирлын цаг агаарын төлөв, 5 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээ, байгаль орчин, хөдөө аж ахуйн цаг уурын 10 хоног тутмын мэдээллийг хугацаанд нь гаргаж радио, телевиз, байгууллагын вэб хуудас, электрон самбар, сонин зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд хүргэж байна.

Голланд улсын санхүүжилттэй “Байгалийн нөөцийн менежментийн үндэсний гео-мэдээллийн төв” төслийн хүрээнд БНХАУ-ын FУ-2С байран хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах газрын станцын антены суурийг бэлтгэх, тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг гүйцэтгэснээр 5 дугаар сарын 02-ноос эхлэн дэлхийн зүүн уртрагийн 5 градусаас 160 градус, хойд өргөргийн 60 градусаас өмнөд өргөргийн 60 градус хүртэлх нутгийг хамарсан 1 цаг тутмын хиймэл дагуулын мэдээг 24 цагийн туршид тасралтгүй хүлээн авч ашиглах боллоо.

Хиймэл дагуулын мэдээгээр ой хээрийн түймрийн голомтын мониторинг хийх ажлын хүрээнд Ховд, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Архангай, Дорнод, Булган зэрэг 9 аймгийн 20 сумын нутагт гарсан 69 удаагийн түймрийн голомтыг илрүүлэн зураглаж, төвийн веб хуудсанд тавих, орон нутагт дамжуулах, ОБЕГ-т мэдээлэх ажлыг тус тус хийж гүйцэтгэв.

### **Барилга, хот байгуулалтын салбарт:**

Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Эдийн засгийн байнгын хороогоор 2007 оны 04 дүгээр сарын 09-нд хэлэлцүүлж, УИХ-ын эдийн засгийн байнгын хороо, УИХ дахь МАХН-ын бүлгээс өгсөн чиглэлийн дагуу төсөлд засвар хийж холбогдох газруудад хүргүүлэв.

“Хот байгуулалтын тухай” болон “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхээр УИХ-ын тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэгт ажиллан төсөлд засвар өөрчлөлт хийж байна.

“Хүн амыг орон сууцаар хангах, барилгын салбарт ажлын байр нэмэгдүүлэх” хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлэхээр УИХ-д өргөн бариад байна.

“Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил, нийтийн аж ахуйн үйлчилгээ, цахилгаан шат, өргөх кран угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилан дүгнэлт гаргах комисс”-ын дүгнэлтийг үндэслэн сайдын тушаалаар “тусгай зөвшөөрөл” хүссэн 81 аж ахуйн нэгжээс барилга угсралтын ажлаар 54, барилгын зураг төсөл боловсруулах ажлаар 13, нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх ажлаар 1 аж ахуйн нэгжид тус тус “тусгай зөвшөөрөл” олгов.

40000 орон сууц хөтөлбөрийн хүрээнд шинэ хотхон байгуулах зорилгоор Богдхан уулын тусгай хамгаалалттай газраас 837.1 га газрыг улсын тусгай хэрэгцээнээс гаргаж, “Богдхан дархан цаазат уул”-ын хилийн заагийг шинэчлэн батлах тухай УИХ-ын тогтоолын төсөлд яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.



Барилга, хот байгуулалтын сайдын 75 дугаар тушаалаар 12 аж ахуйн нэгж байгууллагуудад газар зохион байгуулалт, геодезийн тусгай зөвшөөрөл олгож, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулав.

БНЧУ-ын Ерөнхий сайд М.Тополанкын урилгаар Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт тэргүүтэй төлөөлөгчид Чех улсад 2007 оны 05 дугаар сарын 12-17-нд ажлын айлчлал хийж, удирдамжийн дагуу ажиллаж, тавьсан зорилтоо биелүүлэв.

Чех улсын Зүүн Азийн худалдааны танхимын шугамаар ирсэн бизнесийн төлөөлөгчидтэй 10000 орон сууц барих “Эко Евро барилга” төсөл, АРПИЛ технологи, Экохавтан үйлдвэрлэх технологи нийлүүлэх төсөл, Сургалтын төв байгуулах төслүүд дээр хамтран ажиллаж төслийн эхний шатыг боловсруулав.

Азийн хөгжлийн банк, Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яамны хооронд ядуурлыг бууруулах Японы сангаас үзүүлэх тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх “Хот суурин газрын гэр хорооллын нөхцлийг иргэдийн оролцоотой сайжруулах” төслийн талаар санамж бичиг байгуулав.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр 2007-2012 онд хэрэгжүүлэх Хот байгуулалтын салбарын төслийн Зээлийн гэрээг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэв.

### **Батлан хамгаалах салбарт:**

“Дайчилгааны бэлтгэл үүрэгтний сургалтыг зохион байгуулах журамд өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоол”-ын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээ.

“Хааны эрэлд-2007” энхийг сахиулах ажиллагааны олон улсын хамтарсан хээрийн сургалт, дадлагын бэлтгэлийг хангах тухай”, “Явган цэрэг эсэргүүцэх мин /ЯЦЭМ/-тэй холбоотой мэдээ, мэдээллийг дотооддоо боловсруулах, хадгалах, солилцох бусад яам, агентлаг, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд түгээх журам”-ын төслийг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн 5 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэв.

БНХАУ-ын Ардын чөлөөлөх армийн Жанжин штабын дарга Лян Гуанле 2007 оны 05 дугаар сарын 26-29-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ. Тэрээр ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Ц.Тогоогийн хамт Монгол Улсад үзүүлэх буцалтгүй тусламж олгох тухай гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурлаа.

“Иракийн эрх чөлөө” олон улсын цэргийн ажиллагаанд оролцож буй цэргийн багийн ҮИ ээлжийн бүрэлдэхүүн Олон үндэстний дивиз /төв-өмнөд/-ийн штаб байрлах Ад Дивинях хот дахь “Эко” баазын аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын үүргээ амжилттай биелүүлж байна.

Сиерра Леон Улсад зохион байгуулж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй цэргийн багийнхан тус улсын Фрийтаун хот дахь НҮБ-ын Нарлаг базад байрлан уг бааз болон Тусгай шүүх дээр 2 хуваагдан үүрэг гүйцэтгэж байна. Ирак, Сиерра Леонд үүрэг гүйцэтгэж буй бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, хангалт, сэтгэл санааны байдал сайн, цаашид үүрэг гүйцэтгэх бүрэн боломжтой байна.

Баруун Сахар, Конго, Судан, Этиоп, Эритрид НҮБ-ын явуулж буй энхийг сахиулах ажиллагаанд Зэвсэгт хүчний 11 офицер цэргийн ажиглагчаар үүргээ хэвийн гүйцэтгэж байна.

“Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-т оролцож байгаа сургалтын хөдөлгөөнт багийн ҮИ ээлжийн бүрэлдэхүүн гал удирдах багаж, коллиматорын тухай хичээлийг англи, орос хэл дээр артиллерийн сургалт хариуцсан офицер, ахлагч нарт орчуулгатай заах бэлтгэл ажлыг хангаж, Афганистаны 6 орчуулагчтай хамтарсан сургалт зохион байгуулав.

**Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт:**

Боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т “Бүрэн дунд боловсролыг 12 жилд эзэмшүүлнэ”, 12.4-т “Ерөнхий боловсролын сургуульд 6 настай хүүхдийг элсүүлнэ” гэж заасны дагуу 2008-2009 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэхтэй холбогдуулан тухайн хичээлийн жилээс 72-83 сартай хүүхдийг 6 настай гэж тооцон сургуульд элсүүлэхээр БСШУ-ы сайдын 2007 оны 162 дугаар тушаалаар шийдвэрлэлээ. Энэхүү шийдвэрийн хүрээнд 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэх зааврыг боловсруулж байна.

Энэ хичээлийн жилд Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулахаар иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 19 саналаас судлан Төмөр замын МСҮТ, Говьсүмбэр аймаг дахь МСҮТ, “USI” МСҮТ-дэд сургалт явуулах урьдчилсан зөвшөөрлийг үүсгэн байгуулагч нарт олголоо.

Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад оюутан сургах журмын дагуу 2007-2008 оын хичээлийн жилд Өвөр Монголын өөртөө засах орны тэтгэлгээр тус улсад суралцах 100 оюутныг сонгон шалгаруулах ажлыг БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулсны гадна БНСУ-ын “Ханжин” группын “XXI зуун-Солонгос судлалын сан”-ийн шугамаар тус улсад суралцах бакалаврын 4, магистрантурын 4 хүн суралцуулахаар сонгон шалгаруулалтын журмыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлалаа. Суралцагчдын тоо өмнөх жилийнхээс 2-оор нэмэгдсэн байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд “Монгол хөөмий үндэсний хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлжээ.

Монгол ардын уртын дууны тухай баримтат кино бүтээхээр 2.2 сая санхүүжилтийг БСШУ-ы сайдын 2007 оны 175 дугаар тушаалаар шийдвэрлэсний зэрэгцээ уг тушаалаар Уртын дуучдын улсын уралдааныг зохион байгуулах төсөв, удирдамж, хорооны бүрэлдэхүүнийг баталлаа.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд “Чингис хаан ба түүний залгамжлагчид” үзэсгэлэнг 2005 оноос эхлэн европын орнуудад гаргаж эхэлсэн бөгөөд энэ оны 5 дугаар сарын 21-ээс эхлэн уг үзэсгэлэнг БНУУ-ын Будапешт хот дахь Үндэсний түүхийн музейд гаргаж эхэллээ.

Соёл, урлагийн нэн хэрэгцээтэй мэргэжлийн чиглэлээр гадаад оронд мэргэжилтэн бэлтгэх, тэдний мэргэшлийг дээшлүүлэх ажлын хүрээнд Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 2007-2008 оны хичээлийн жилд Оросын холбооны улсад соёл, урлагийн чиглэлээр 13 мэргэжил дээшлүүлэгч, аспирант, 12 оюутан сургахаар ОХУ-ын Соёлын яамтай хамтран шалгаруулалтыг зохион байгууллаа.

Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Оросын хүмүүнлэгийн шинжлэх ухааны сантай хамтран 2007 оноос эхлэн үйлдвэрлэлд нэвтрүүлэх 238.0 сая төгрөгийн санхүүжилт бүхий 12 зэхэц, мөн 84.8 сая төгрөгийн санхүүжилт бүхий 15 суурь судалгааны ажлыг тус тус хэрэгжүүлэхээр БСШУ-ы сайдын 143 дугаар тушаалаар 2007 онд зэхэц ажилд шаардагдах 30.0 сая, БСШУ-ы сайдын 150 дугаар тушаалаар суурь судалгааны ажилд шаардагдах 27.8 сая төгрөгийг баталлаа.

**Зам, тээвэр, аялал жуулчлалын салбарт:**

Монгол Улсын Засгийн газрын Худалдаа, тээврийг хөнгөвчлөх Үндэсний хорооны веб сайтыг загварыг боловсруулж байнгын ажиллагаатай болгов. Үндэсний хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Ачаа, барааны хил гаалийн үзлэг шалгалтыг явуулах нөхцлийн тухай олон улсын конвенц /Женев, 1982/-ид нэгдэн орох тухай хуулийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулав.

Шинэ Зеланд Улсад 2001 онд байгуулсан “Олон улсын агаарын тээврийг либералчлах тухай олон талт хэлэлцээр”, түүний “Зөвхөн агаараар ачаа тээвэрлэхэд хэрэглэх тухай нэмэлт, өөрчлөлт”-д нэгдэн орох, Далайд хүний аюулгүй байдлыг хангах тухай 1974 оны Олон Улсын конвенцийн 1988 оны Протокол, Даацын тэмдэглэгээний тухай 1966 оны Олон Улсын конвенцийн 1988 оны Протокол, Далайн олон улсын байгууллагын тухай конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах 1991 оны Протокол, Далайг хөлөг онгоцны бохирдлоос сэргийлэх тухай 1973 оны Олон Улсын конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1997 оны Протоколд нэгдэн орох тухай хуулиудын төслийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулав.

Баруун босоо тэнхлэгийн буюу Азийн авто замын АН-4 чиглэлийн Ярант-Ховд-Өлгий-Цагааннуурын авто замыг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр барих төслийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсад ажилласан Азийн хөгжлийн банкны үнэлгээний хэсэгтэй хамт төслийн замтай танилцаж орон нутгийн иргэд, төлөөлөгчдийн саналыг авах, холбогдох мэдээллийг цуглуулах анхан шатны ажлыг хийж санамж бичиг үйлдэв.

“Бүс нутгийн авто зам хөгжүүлэх” төслийн NP2 буюу 62.2км-ээс Замын-Үүд /62км/ чиглэлийн эргэн төлөгдөх нөхцөлтэй тендерийг зарлав.

Кувейтийн сангийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж байгаа Эрдэнэт-Булган-Уньт чиглэлийн авто замын ЗБ, ЗС хэсгүүдийн гүйцэтгэгчээр шалгарсан “Насны зам” ХХК-тай гэрээ байгуулав.

Хөвсгөл нуурын эрэгт Усан замын тээврийн хяналт, зохицуулалтын байр барих, аврах хэрэгсэл, моторт завь, холбооны хэрэгсэл нийлүүлэх тендерийг тус яамнаас зарласанд 6 аж ахуйн нэгж оролцохоор тендерийн материал худалдан авснаас 1 дүгээр багцад “Энержи стар”, 2 дугаар багцад “Цагаан уул-Тэрхэн” ХХК-иудыг шалгаруулж гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлээд байна.

“Аэромонголиа” ХХК-ийг Ховд-Урумч нислэгийн шугамд томилох асуудлыг БНХАУ-ын талд холбогдох шугамаар мэдэгдэж шийдвэрлүүлэх хүсэлтийг Гадаад хэргийн яаманд уламжлав. Ховдын нисэх буудалд олон улсын нислэг хийхэд хил, гааль, хилийн мэргэжлийн хяналтын болон холбогдох бусад байгууллагуудын үйл ажиллагааг хангах асуудлыг Иргэний нисэхийн ерөнхий газраас хариуцан зохицуулж байна.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлтээ гаргасан аж ахуйн нэгжүүдийг ангилал тус бүрийн шаардлагын дагуу хянан үзэж гадаад орноос жуулчин хүлээн авах тур-оператор ангиллаар 10, олон улсын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх тур-оператор ангилаар 2, дотоодын аялал жуулчлалын үйл ажиллагааг эрхлэх ангиллаар 1 байгууллагад гэрчилгээг тус тус олгов.

АНУ-ын хэвлэл мэдээллийн томоохон байгууллага болох Strategic Media компанитай хамтран Монголын аялал жуулчлалын талаархи сурталчилгааны “Beautiful World-Mongolia” нэг цагийн цуврал баримтат кино бүтээх гэрээ байгуулав.

Булган аймгийн Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн 109км, Хөшөөцайдам-Өгийн нуур чиглэлийн 10км, Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 23км, Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн 30.4км, Өндөрхаан-Сүмбэр чиглэлийн 50км, Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 68км, Цэцэрлэг-Цэцүүх чиглэлийн 53км, авто замуудын барилгын ажлын нээлтийг хийв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих Дорнод аймгийн Алтан голын 17 у/м төмөрбетон гүүрийн барилгын гүйцэтгэгчийг сонгох үнэлгээг хийж дуусган гэрээ байгуулах мэдэгдлийг хүргүүлэв.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн авто замын 18-ийн худаас км 62+200 хүртэлх 62км хатуу хучилттай авто зам барих олон улсын нээлттэй тендерийн үнэлгээний дүгнэлтийг хийж дуусган хянуулахаар Сангийн яаманд хүргүүлэв.

Улсын чанартай А-0401 дугаартай Улаанбаатар-Дархан чиглэлийн хатуу хучилттай авто замын 69-72 дахь километр гадаргуун дан өнгө боловсруулалт хийх тендерийн баримт бичгийн боловсруулан зарлав.

Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замын техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг зарлав.

Улаанбаатар хотын Яармагийн гүүрээс Баянзүрхийн товчоо хүртэл барих хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан хайгуул, зураг төсөл боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулах хязгаарлагдмал тендерийг зарлав.

Баянхонгор-Нарийн тээл чиглэлийн 50 км, Улаанбаатар-Налайх-Агуйтын чиглэлийн 43 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан хайгуул зураг төслийн зөвлөхийг сонгон шалгаруулж тус тус гэрээ байгуулав.

### **Нийгмийн хамгааллын салбарт:**

Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 35 дугаар захирамжаар байгуулагдсан Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны хуралдааныг зохион байгуулав.

Боловсролын салбарын ажилтны цалин хөлсний тогтолцоог шинэчлэх, боловсронгуй болгох талаар БСШУЯ, Сангийн яамтай санал солилцон ерөнхий зарчмыг тохирч, Засгийн газарт танилцуулав. Үүнтэй холбогдуулан төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох үүрэг өгсөний дагуу нийт төрийн албан хаагчдын цалингийн тогтолцоог өөрчлөн шинэчлэх асуудалтай нэгтгэн судалж, шийдвэрлүүлэхээр холбогдох тооцоо судалгааг хийж байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон харьяалах байгууллагагүй иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу нэг хүнд 145 мянган төгрөг олгох асуудлыг шийдвэрлүүлж, 26 орчим сая төгрөгийг 180 хүнд Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсээр дамжуулан олгоод байна.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үндэсний хорооны хурлыг зохион байгуулж, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрийн явц болон “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн төслийг хэлэлцүүлж, санал авав.

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж Засгийн газрын 2007 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 109 дүгээр тогтоолоор батлуулав. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн шинэ итгэлцүүрийг хэрэглэж нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийг дахин тооцоолох бөгөөд энэ арга хэмжээнд нийт 60.2 мянган хүний тэтгэвэр дунджаар 16.5 мянган төгрөгөөр нэмэгдэх юм. Тэтгэврийн зөрүүг арилгах арга хэмжээнд 2007 оны сүүлийн хагас жилд 6.0 тэрбум төгрөг, тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэхэд 4.0 тэрбум төгрөг тус тус зарцуулах бөгөөд эдгээр арга хэмжээг авахад нийт 10.1 тэрбум төгрөг энэ оны сүүлийн хагас жилд нэмж шаардагдах болно.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох асуудлыг хэлэлцүүлж, Засгийн газрын 110 дугаар тогтоолоор батлуулав. Уг тогтоолоор бүрэн тэтгэврийн доод хэмжээг 56250 төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 37500 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, 2007 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс олгохоор боллоо. Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 51750 төгрөг байгааг 56250 төгрөг болгоход 133.0 хүн хамрагдаж 3.3 тэрбум төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 34500 төгрөг байгааг 37500 төгрөг болгоход 38.9 мянган хүн хамрагдаж 0.7 тэрбум төгрөг тус тус шаардагдах юм.

Хүүхдийн асрамж, халамж, хамгааллын үйлчилгээний стандарт боловсруулах ажлын хэсгийн хуралдааныг хоёр удаа зохион байгуулж, стандартын төслийн эхний хувилбарыг боловсруулаад байгаа бөгөөд хүүхдийн асрамж, халамжийн төвүүдийн үйл ажиллагаатай танилцахаар бэлтгэл ажлыг хангав.

НХХЯ, НҮБ-ын Хүн амын сан хамтран 2007-2011 онд хэрэгжүүлэх “Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Хүн ам ба хөгжил, жендэрийн асуудлыг ядууралтай уялдуулах нь” төслийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангав. Энэ ажлын хүрээнд төслийн эд хөрөнгийн тооллого хийж, 2 дугаар улирлын үйл ажиллагааны санхүүжилтын хүсэлтийг боловсруулан НҮБ-ын Хүн амын санд хүргүүлэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2007 оны хөрөнгө оруулалтад тусгагдсан Сүхбаатар аймгийн 8 сумын гэр оронгүй иргэдийг гэржүүлэх зориулалтаар тусгагдсан 15.0 сая төгрөгийн санхүүжилтийн асуудлыг Сангийн яамаар шийдвэрлүүлэн санхүүжүүлэв.

2007 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар тэтгэврийн даатгалын санд нийт 71.2 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлагдаж нийт 73.2 тэрбум төгрөгийн тэтгэврийг олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 104 хувиар буюу 2.3 тэрбум төгрөгөөр даван биелж өссөн дүнгээр 59.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага өмнөх сараас 261.7 сая төгрөгөөр нэмэгдэж 12 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Нийгмийн халамжийн санд нийт 31.8 тэрбум төгрөг хуримтлагдаж, Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, арга хэмжээ үйлчилгээнд нийт 32.0 тэрбум төгрөг зарцуулсан байна. 2007 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар Нийгмийн халамжийн арга хэмжээ, үйлчилгээнд нийт 1208.4 мянган хүн хамрагдсанаас 1029.6 мянга буюу 85.2 хувь нь улсын төсвөөс олгосон тэтгэмж, тусламжинд, 44.7 мянга буюу 3.7 хувь нь халамжийн тэтгэвэрт, 71.9 мянга буюу 5.9 хувь нь нөхцөлт мөнгөн тэтгэмжинд, 56.2 мянга буюу 4.7 хувь нь ахмад настан, ХБИ-дэд олгосон хөнгөлөлтөнд, 6.1 мянга буюу 0.5 хувь нь бусад үйлчилгээнд хамрагдсан байна.

#### Улсын төсвөөс олгосон тэтгэмж, тусламж

- Хүүхдийн мөнгөн тэтгэмжинд 896.5 мянган хүүхдэд 10.8 тэрбум төгрөг,
- Шинээр төрсөн 16.9 мянган хүүхдэд 1.7 тэрбум төгрөг,
- Шинээр гэр бүл болсон 4.0 мянга гаруй өрхөд 2.0 тэрбум төгрөг,
- Алдар цолтой 3.2 мянган ахмадуудад 213.1 сая төгрөг,
- Алдарт эхийн одонтой 109.1 мянган эхчүүдэд 7.2 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

#### Нөхцөлт мөнгөн тэтгэмж

- Жирэмсэн болон хөхүүл 38.9 мянган эхчүүдэд 2.5 тэрбум төгрөг,
- Ахмад настныг асарч буй 2.5 мянган иргэнд 128.8 сая төгрөг
- ХБИ-ийг асарч буй 4.2 мянган иргэнд 232.2 сая төгрөг
- Жирэмсэн болон амаржсан 4.7 эхчүүдэд 117.3 сая төгрөг,
- Хүүхэд асарсаны тэтгэмжинд 21.2 мянган иргэнд 1.0 тэрбум төгрөг
- Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмжинд 343 иргэнд 26.4 сая төгрөгийг тус тус олгосон байна.

#### Ахмад настан ХБИ-дэд олгосон хөнгөлөлт

- 88.1 хувь буюу 49.5 мянга нь ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлтөнд
- 11.8 хувь буюу 6.7 мянга нь ХБИ-дэд үзүүлсэн хөнгөлөлтөнд тус тус хамрагдсан байна.

Бусад үйлчилгээ

- Нийгмийн халамжийн үйлчилгээнд 362 иргэн хамрагдаж 27573.2 мянган төгрөг,
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 4437 иргэн хамрагдаж 234.0 сая төгрөг олгосон байна.

Тайлант хугацаанд эдийн засгийн идэвхитэй хүн ам 1042.8 мянга, үүний дотор ажиллагсад 1009.9 мянга, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд ажил идэвхитэй хайж бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 32.9 мянга болсон байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 33.9 мянга болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилгүй иргэдийн тоо 143 хүнээр буюу 0.4 пунктээр нэмэгдэж, ажилгүйдлийн түвшин 3.2 хувьтай байна.

2007 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар нийт 11993 иргэнийг ажилд зуучлан оруулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1658 хүнээр буюу 16.0 пунктээр нэмэгдсэн байна. Ажил олгогчдоос нийт 14222 ажлын байрны захиалга ирүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2768-аар буюу 24.2 пунктээр нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд 19006 ажлын байр шинээр бий болгосон ба ажлын байрны 65 хувь нь байнгын, 35 хувь нь улирлын чанартай ажлууд байна.

2007 оны 5 дугаар сарын 1-ний байдлаар нийт 5151 ажилгүй иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулвал 945-аар буюу 15.5 пунктээр буурсан байна. Мөн нийт 3212 иргэн ажилгүйдлийн тэтгэмжинд хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулвал 1468 хүнээр 1.5 дахин нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд нөхөн олговорт улсын төсвөөс 179.9 сая төгрөг хувиарилж 1012 хүнд 187.3 сая төгрөг олголоо. Энэ хугацаанд 227 хүн нөхөн олговор олгох бүртгэлтэй хүмүүсийн тооноос хасагдаж өндөр насны тэтгэвэр авах эрх нь үүссэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд нийт 2795.9 сая төгрөгийн хөрөнгө төвлөрүүлсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд давхардсан тоогоор 47142 иргэн хамрагдаж тэдэнд нийт 2328.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Эдгээрийг тус бүрд нь авч үзвэл:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ

- Ажилд зуучлахад нийт зарцуулсан хөрөнгийн 1.9 хувь буюу 44.7 сая төгрөгийг зарцуулж 11993 иргэнийг,
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангахад нийт зарцуулсан хөрөнгийн 1.6 хувь буюу 37.3 сая төгрөгийг зарцуулж 22781 иргэнийг,
- Мэргэжил олгох давтан сургалтад хамруулахад нийт зарцуулсан хөрөнгийн 10.6 хувь буюу 246.7 төгрөгийг зарцуулж нийт 5151 иргэнийг тус тус хамруулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ

- Нийтийг хамарсан ажил зохион байгуулахад нийт зарцуулсан хөрөнгийн 3.6 хувь буюу 83.2 сая төгрөгийг зарцуулж 1250 иргэнийг хамруулсан байна.
- Ажил олгогчийг дэмжихэд нийт зарцуулсан хөрөнгийн 3.4 хувь буюу 78.6 сая төгрөгийг зарцуулж 301 иргэнийг хамруулсан байна.
- ХХҮХ-дийн материаллаг баазыг бэхжүүлэхэд нийт хөрөнгийн 5.4 хувь буюу 125.4 сая төгрөгийг,
- Хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэх иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд нийт хөрөнгийн 72.1 хувь буюу 1678.6 сая төгрөгийг,

- Сургалт семинар зохион байгуулахад нийт хөрөнгийн 1.2 хувь буюу 27.0 сая төгрөгийг,
- Хяналт шалгалтын зардалд 0.3 хувь буюу 6.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **Түлш, эрчим хүчний салбарт:**

Салбарын 2007-2008 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд Багануурын уурхай, “Багануурын дулааны станц” ХК, “Багануур Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ХК, “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” ХК-ийн Багануурын салбар, Шарын голын уурхай, Шарын голын дулааны станцын ажил байдалтай тус тус танилцан холбогдох хүмүүстэй уулзаж шаардлагатай арга хэмжээг авахуулахаар ажиллалаа.

Дарханы дулааны цахилгаан станцад турбогенератор шинээр суурилуулах “Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх” төслийн зөвлөх шалгаруулах үнэлгээний хорооны ажлын цар хэмжээг тодорхойлсон жагсаалтыг Германы сэргээн босголтын банкны мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж, зөвлөх шалгаруулах тендерийг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр зарлаад байна.

“Нүүрснээс газрын тосны бүтээгдэхүүн гарган авах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах”, “Нүүрсний хими-технологийн судалгааны лаборатори барьж байгуулах”, “Хийн баллоныг шалгах, баталгаажуулах, туршиж тохируулах төв болон шинжилгээний лаборатори барьж байгуулах” техникийн нөхцөл, материалыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлан нээн, үнэлгээний хороо үнэлж байна.

Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр баригдах Улаанбаатар хотын Хайлаастын гэр хорооллын 110/35/10 кВ-ын дэд станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж нээгээд үнэлгээний хороо үнэлж байна.

“Баруун” 110/10 кв-ын дэд станцыг өргөтгөх барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж нээн гүйцэтгэгчийг шалгаруулаад байна.

Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжигдэх 100 000 нарны гэр хөтөлбөрийг хэрэгжүүлэх 50 ваттын 10 000 ширхэг нарны цахилгаан үүсгүүрийн иж бүрэн системийг нийлүүлэх, мөн тус сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх малчин өрхийг нарны эрчим хүчээр хангах 50 ваттын 8 900 ширхэг нарны цахилгаан үүсгүүрийн иж бүрэн системийг нийлүүлэх гүйцэтгэгчийг тус тус сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний ажил хийгдэж байна.

БНСУ-ын “L-SYSTECH, BIONICS, PRO-THINKER” компанийн түншлэлтэй 2006 оны 12 дугаар 25-ны өдөр байгуулсан 50 ваттын 21 500 ширхэг нарны цахилгаан үүсгүүрийн иж бүрэн системийг нийлүүлэх 100 000 нарны гэр-2006/14 тоот гэрээг бүхэлд нь цуцалсантай холбогдуулан Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх үндэсний арбитра нэхэмжлэл гарган холбогдох хууль зүйн ажиллагааг хийж байна.

Эгийн голын усан цахилгаан станцын төслийн гүйцэтгэгчээр шалгарсан “Пойри” компанитай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах бэлтгэлийг хангаад байна. Мөн тус станцын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тодотгол хийж, Байгаль орчны яамаар батлууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж буй Налайхын дулааны станцын зуухны засварын ажлыг гүйцэтгэх байгууллагыг шалгаруулах тендерийг зарласнаас “Хасуу эрчим” компани шалгарч ажил гүйцэтгэх гэрээг байгуулаад байна.

Ховд аймгийн Мянгад-Манханы 110 кВ-ын 121 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын тендерийг зарлан үнэлээд гэрээ байгуулах зөвшөөрөл авахаар Сангийн яаманд хүргүүлээд байна.

Завхан аймгийн Цагаанчулуутын 110/15 кВ-ын дэд станцын хязгаарлагдмал тендерийг зарлаж нээгээд үнэлгээ хийн гэрээ байгуулж байна.

Төв аймгийн Зуунмодны дулааны шугамын шинэчлэлт тендерийн материалыг хүлээн авч, үнэлгээг хийж байна.

Дулааны цахилгаан станцаас Дархан хот хүртэлх дулааны магистраль шугамын шинэчлэх ажлын тендерийн үнэлгээг хийж гэрээ байгуулах зөвшөөрөл авахаар Сангийн яаманд хүргүүлээд байна.

Гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр 2007 онд хэрэгжиж буй төслүүдийн ашиглалтын мэдээг 5 дугаар сарын 1-ний байдлаар нэгтгэн гаргаснаас 2007 онд зээлийн 7, тусламжийн 5 төсөл нийт 104,27 сая ам долларын ашиглалт хийхээр төлөвлөгдөөд байна. /Үүнд: зээлийн хөрөнгө-93,1 сая ам.доллар, тусламжийн хөрөнгө-11,32 сая ам доллар/ 4 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар зээлийн 2,03 сая ам долларын гүйцэтгэл, тусламжийн 304.0 мянган еврогийн гүйцэтгэлийг тус тус Сангийн яаманд уламжилж санхүүжилтийг олгуулаад байна.

Салбарт 2007 онд улсын төсвийн болон Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжих 22 төсөл арга хэмжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог байгуулж 21 тендерийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу дүгнэн гэрээг байгуулах ажлыг зохион байгуулж байна.

Улсын төсвөөс алдагдалын санхүүжилт авдаг дизель станц бүхий Завхан, Говь-Алтай аймгийн эрчим хүчний үйлдвэрүүдэд 5 дугаар сарын хуваарьт санхүүжилт болох 323,54 сая төгрөгийг олгууллаа.

### **Үйлдвэр, худалдааны салбарт:**

Япон Улсын Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд “Орон нутагт аж үйлдвэрийн төвлөрөлийг бий болгох боломжийн талаар судалгаа хийж, төслийг Японы талд хүргүүлэв.

“Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг түшиглэн байгуулагдах уулын үйлдвэрт төрийн оролцооны хувь хэмжээг тогтоох, оролцооныхоо хэмжээгээр хөрөнгө оруулалтыг хэрхэн хийх талаар баримтлах зарчим, аргачлалын төсөл” боловсруулав.

“Эко Трейд” ХХК-ийн боловсруулсан “Таван толгойн коксжих нүүрсний ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан”-д хяналт, шинжилгээ хийж, экспертизийн үнэлгээ-дүгнэлт гаргав.

“Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг батлуулахаар ХЗДХЯ-нд хүргүүлэв.

“Технологи дамжуулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн үзэл баримтлал боловсруулахтай холбогдуулан Монгол Улсын инновацийн тогтолцооны загварын төсөл боловсруулав.

Мод, модон түүхий эд материал импортлох асуудлаар “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөл, танилцуулгыг боловсруулав.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуультай уялдуулан “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл боловсруулав.

“Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого, шийдвэрлэх асуудлууд” баримт бичиг



боловсруулж Сайдын зөвлөлийн хуралдаанаар болон УИХ-ын олонхийн бүлгээр хэлэлцүүлж ЭЗБХ-оор хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.

Ой, модны үйлдвэрлэлийн чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн 2-р үе шатны /2007 – 2010 оны/ зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон 2007 оны төлөвлөгөөг боловсруулан Сайдын тушаалаар батлуулав.

2007 оны хөнгөлөлттэй зээлийн Хамтран ажиллах гэрээг Хас, Зоос, Монгол шуудан банкуудтай гарын үсэг зурах ажлыг зохион байгуулав.

Засгийн газрын 2005 оны 245 дугаар тогтоолоор батлагдсан “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 1-р үе шатны төлөвлөгөөнд ҮХЯ-наас хариуцах болон оролцон хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг гаргав.

“ЖДҮ-ийг дэмжих сан”-г 21 аймагт байгуулахаас 9 аймагт гэрээ хийгдэж байгуулагдаад байна. 7 аймаг гэрээ хийх талаар саналаа ирүүлээд байна.

“Монголд үйлдвэрлэл хөгжүүлэ” төслийн хүрээнд “Нэг суурин, Нэг бүтээгдэхүүн” санаачилгын 2 дахь шатны бүтээгдэхүүн шалгаруулах Техникийн хороонд ажиллаж 21 бүтээгдэхүүнд үнэлгээ өгөв.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын асуудлаар дэмжлэг хүсэх тухай албан бичгийг “Бороо Гоулд” ХХК, “Алтан дорнод Монгол” ХХК, “Монполимет” ХХК-иудад явуулж цианитаар хордсон хөрсийг зайлуулах арга хэмжээ авч байна.

Засгийн газрын хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу улсын хэмжээнд химийн хорт бодисын үзлэгийг зохион байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн дагуу “Гадаадын иргэдийн ажлын байрны төлбөрийг зарцуулах журам”-ын төслийг НХХЯ-тай хамтран боловсруулав.

Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг дунд хугацаанд хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах, тохиролцох асуудлаар санал боловсруулж хөтөлбөр боловсруулахад баримтлах чиглэл, Засгийн газраас гаргах шийдвэрийн төсөл, холбогдох танилцуулгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

БНХАУ-ын Элчин сайдад Монгол Улс ДХБ-д элсэхдээ боловсруулаагүй ноолуурын экспортын татварыг цуцлах талаар авсан үүрэг амлалтыг хэрэгжүүлэх хугацааг 5 жилээр сунгах асуудлыг ДХБ-ын Барааны хорооны хуралд хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар хүсэлт тавьж Хятадын тал манай хүсэлтийг дэмжих чиглэлээр ажиллаж байгаа тухай мэдээлэл авав.

АНУ-ын хөнгөлөлтийн системд шинээр хамрагдах болсон гар урлалын бараа бүтээгдэхүүнд Гарал үүслийн гэрчилгээг МҮХАҮТ-аар олгуулахаар тохиролцож дардас, гарын үсгийн загварыг АНУ-ын Элчин сайдын яаманд явуулав.

Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Сайд нарын хурлаар хэлэлцэх асуудлаар цахим хэлэлцүүлэг зохион байгуулах асуудлаар Женев дахь Байнгын төлөөлөгчид захидал илгээж бэлтгэлийг хангахад хамтран ажиллаж дэмжлэг үзүүлэхийг хүсэв.

Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савыг улсын бүртгэлд хамруулах, савны техникийн паспортын загварыг батлуулах тухай болон ҮХЯ, УМХГ-ын сайд нарын хамтарсан тушаал гаргав.

### **Хүнс, хөдөө аж ахуйн салбарт:**

”Мянган малчны чуулган”-ыг 6 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулахаар бэлтгэл ажлыг төвлөвлөгөөний дагуу зохион байгуулж, ажлын хэсгийг хуралдуулан холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

”Ногоон хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 45 тонн төмсний үр, 6 тонн төрөл бүрийн хүнсний ногооны үр, бордоо, хүлэмжийн нийлэг хальсийг батлагдсан хуваарийн дагуу 22 аймаг, нийслэлийн ХХААГ болон байгууллага, иргэдэд олгох ажлыг зохион

байгуулав. Түүнчлэн хөтөлбөрийн хүрээнд нийлүүлэгдсэн бага оврын тракторыг хүлээн аваад байна.

БНХАУ-ын буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн бага оврын трактор дагалдах хэрэгслийн хамт 341 ширхэг, 1 га-гийн услалтын систем 83 ширхэг, 25 га-гийн услалтын систем 41 ширхэгийг борлуулж, хуримтлалын санг бүрдүүлээд байна.

Царцааны тархалт хөнөөлийн тодотгох судалгааг Төв, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн царцаа тархсан сумдад хийлгүүлэн холбогдох дүнг үндэслэн 6 дугаар сард багтаан 90.0 мянган га талбайд химийн аргаар царцаатай тэмцэх ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэв.

Үлийн цагаан оготны тархалт хөнөөлийн хаврын тодотгох судалгааны дүнг үндэслэн бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч амьтантай байгаль орчинд халгүй аргаар тэмцэх ажлыг Архангай, Булган, Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай зэрэг 5 аймгийн 44 сумын нийт 185.0 мянган га-аас доошгүй талбайд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, шаардагдах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэн зохион байгуулж байна.

“Махны чиглэлийн үхрийн үржлийн аж ахуйн төсөл”, “Бүрэн найрлагат эрдэс тэжээлийн цехийн төсөл”, “Тэжээлийн олон наст ургамлын үр үржүүлэх аж ахуйн нэгжийн төсөл”, “Махны чиглэлийн хонь, үхрийн тэжээл үйлдвэрлэх аж ахуйн нэгжийн төсөл”, “Махны чиглэлийн хонины үржлийн аж ахуйн төсөл” шалгаруултад оролцохоор орон нутгаас ирүүлсэн 52 материалыг нэгтгэж сонгон шалгаруулах ажлыг гүйцэтгэж байна.

ДХХААБ-аас хэрэгжүүлж байгаа “Өндөр хоруу чанартай шувууны томуугийн бэлэн байдлыг бэхжүүлэх техникийн туслалцаа” төслийн хүрээнд 11 аймгийн 44 нууранд тандалтын сүлжээ байгуулахад оролцох ажилтнуудыг хамруулсан сургалтыг Архангай, Ховд, Хэнтий, Увс аймгуудад зохион байгууллаа. Сургалтаар шувууны томуугийн тандалт хийх болон тухайн нууранд байдаг түгээмэл тохиолдох шувуудыг таних аргачлал, газар зүйн мэдээллийн систем, GPS багаж ашиглах, томуугийн сэжигтэй тохиолдлын үед лабораторит дээж илгээх, хадгалах, түргэн тестийг хэрхэн ашиглах, дээжийг шинжлэх талаар зөвлөмж өгөв.

Малын үржлийн арга хэмжээнд 2007 онд шаардагдах багаж төхөөрөмж нийлүүлэгчийг сонгох тендерийн баримт бичгийг Үнэлгээний хорооны хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж сониноор зарлуулаад байна.

14 аймагт шинэ худаг барьж байгуулах болон 9 аймагт худаг сэргээн засварлах ажлын гэрээ байгуулж, урьдчилгаа санхүүжилт хийлгэхээр материалыг Сангийн яаманд хүргүүлэв.

Услалтын системийн сэргээн засварлах, шинээр барих тендерт шалгарсан нийт 25 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах ажлыг эхлүүлээд байна.

### **Эрүүл мэндийн салбарт:**

НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Эрүүл мэндийн анхны тусламжийн тогтвортой үйлчилгээ” төслийн хүрээнд төсөл хэрэгжиж буй Баянхонгор, Баян-Өлгий, Дорнод, Увс аймгийн Нэгдсэн эмнэлгүүдэд Эрүүл мэндийн сайдын 2007 оны 123 тоот тушаалаар эмнэлгийн тоног төхөөрөмж хуваарилав.

ДЭМБ-тай хамтран “Олон улсын эрүүл мэндийн дүрмийг хэрэгжүүлэх нь” сэдэвт салбар дундын үндэсний семинарыг зохион байгуулав.

“Халууралт, тууралттай халдварын тандалтыг эрчимжүүлье” уриан дор дархлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулах тухай Эрүүл мэндийн сайдын 2007 оны 131 тоот тушаалыг боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.

2006 онд Тавт вакциныг дархлаажуулалтанд нэвтрүүлсэн талаар тайлан бичиж Вакцин дархлаажуулалтын Глобал санд хүргүүлэв.

Шувууны томуу, томуугийн цартахалтай тэмцэх, сэргийлэх арга хэмжээний бэлэн байдлыг хангах талаар Дэлхийн Банкны зөвлөхүүдтэй хамтран ажиллав.

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 17.4 дэх заалтыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2007 оны 114 тоот тушаалаар Дадлагажигч их эмчийн ажиллах журмыг батлав.

Эрүүл мэндийн сайдын 2007 оны 116 тоот тушаалаар Эмчлэх, сувилах, эм барих мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам, Гадаадын харьяат эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журмыг тус тус шинэчлэн батлав.

Засгийн газрын 2006 оны 283 тоот тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, нийгэм хамт олонд тулгуурлан сэргээн засах үйл ажиллагааг өргөжүүлэн сайжруулах зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй эмнэлэг шалгаруулах болзол”-ыг Эрүүл мэндийн сайдын 2007 оны 127 тоот тушаалаар батлав.

Эрүүл мэндийн яамнаас хэрэгжүүлж байгаа Глобал сангийн “ХДХВ-ийн халдвар эхээс хүүхдэд дамжихаас сэргийлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамж, ажлын төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2007 оны 129 тоот тушаалаар батлав.

Төрийн албанд анх орох иргэний эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам, эрүүл мэндийн хуудасны загварыг Эрүүл мэндийн сайдын 2007 оны 133 тоот тушаалаар батлав.

П.Н.Шастины нэрэмжит клиникийн төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төвийн дүрэм, бүтцийг Эрүүл мэндийн сайдын 2007 оны 137 тоот тушаалаар батлав.

2007 оны 5 дугаар сарын 01-ний байдлаар Монголэмимпекс ХК-ны агуулахад 163 нэрийн нэрийн 496,7 сая төгрөгийн, орон нутгийн эм хангамж компаниудын агуулахад 89-146 нэрийн 446,2 сая төгрөгийн Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн үлдэгдэлтэй байна.

Энэ сард импортын гэрээгээр Нидерландын IDA Foundation эм ханган нийлүүлэх байгууллагаас Бупивикайн, Лидокайны г/х, Протамины сульфат, Хлоргексидин, Флуфеназины деконат, ОХУ-аас Фторотан, Италийн Эстан компаниас мэс заслын бээлий, даралтын аппарат зэрэг эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал, Германы Ротексмедика компаниас Витамин В комплекс, Диклофенак натрийн тариа нийлүүлэгдсэн байна.

Клиникийн эмнэлэг тусгай мэргэжлийн төвүүд, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эмнэлгүүдэд тендерт шалгарсан эм ханган нийлүүлэх байгууллагууд эм, эмнэлгийн хэрэгслийг хуулийн дагуу нийлүүлж, ҮЗШЭмийн хангамж хэвийн байна.

-- о О о --